



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар АА23

Булган сум

**Сургалт зохион байгуулахад  
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, "Процессын дахин инженерчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгавар, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх арга хэлбэрийг өөрчлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнд суурилсан үнэлгээ мониторингийн тогтолцоог хөгжүүлэхээр шинэчлэн найруулсан журмын төслийг танилцуулах ажлын хүрээнд орон нутаг дахь төрийн албан хаагчдад мэдээлэл өгөх сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Сургалт хэлэлцүүлгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ч.Цогбуян)-т, удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т даалгасугай

3. Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах 4,375,000 (дөрвөн сая гурван зуун далан таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011035

Аймгийн Засаг даргын 2024 оны  
06-ны/ний өдрийн 11/322 дугаар  
захирамжийн хавсралт

Төрийн албан хаагчдад зориулсан сургалт, хэлэлцүүлгийн төсөв

д/д	Зардлын нэр	Тоо	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Дүн
1	2	3	4	5	6
Зохион байгуулалтын зардал					
1	Сургагч багш нарын хоол	15	хүн	49,800	747,000
2	Буудал	5	тоо	160,000	680,000
3	Цай, ус, кофе	220	тоо	9,500	2,090,000
4	Хоол (оролцогч) өглөө, өдөр	110	хүн	29,300	3,230,000
5	Бусад зардал				650,000
Нийт дүн					7,397,000